



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

**IP TV системийн хүртээмжийн профайлын
(ITU-T H.702)
зөвлөмжийг стандарт болгон хэрэгжүүлэх
эсэх талаар гаргасан дүгнэлт**

ХХЗХ, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

2024 он

ДАРААХ БИЧИГ БАРИМТУУДАД ТУЛГУУРЛАН ДҮГНЭЛТИЙГ ГАРГАСАН

“ОСДҮ-г хөгжлийн
бэрхшээлтэй иргэдэд
хүртээмжтэй хүргэх,
Улаанбаатар хотын ОСДҮЭ-
ээс авсан хүртээмжийн
үйлчилгээний судалгаа,
тайлан” 2023 он

НЭГ


Recommendation ITU-T
H.702. Accessibility profiles
for IPTV systems
2020 он

ХОЁР

IPTV системийн
үйлчилгээний хүртээмжийг
нэмэгдүүлэх аргачлал,
гарын авлага
2019 он

ГУРАВ

Хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгч интернэт протоколд суурилсан телевизийн (IPTV) хэрэглэгчийн төхөөрөмжөөс доорх гурван төрлийн хүртээмж нэмэгдүүлсэн үйлчилгээг авдаг



ХАДМАЛ ТАЙЛБАР

**Хадмал тайлбар
(captions)**



**Дохионы хэл
(sign language)**



**Аудио хөрвүүлэг
(audio description)**

ПРОФАЙЛУД



RECOMMENDED

Дээрх үйлчилгээнүүд нь мөн дараах профайл гэж тодорхойлогдсон техникийн түвшин, шаардлагуудаар ангилагдсан байна.

Дээр дурдсан гурван үйлчилгээг нэгэн зэрэг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй учир ITU-T H.702 зөвлөмжид IPTV үйлчилгээ эрхлэгч болон Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн онцлог, тэдний үйл ажиллагааны зардал зэрэгт тохируулан энгийнээс эхлээд бүх үйлдлүүдийг багтаасан шаталсан профайлуудыг тодорхойлж өгсөн байна.

01

Суурь профайл (Basic profile)

02

Сайжруулсан профайл (Enhanced profile)

03

Үндсэн профайл (Main profile)



ЗӨВЛӨМЖ

Зөвлөмж байдлаар гаргасан нь



Олон улсын Цахилгаан Холбооны Байгууллагын стандартын газраас IPTV системийн хүртээмжийн профайлыг олон улсад хэрэглэхдээ **зөвлөмж** байдлаар гаргасан нь дараах шалтгаануудтай байна.



ХУВЬ

Тухайн улсын IPTV болон телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөр дэх хүртээмжийн үйлчилгээний төрлүүдийн хувь хэмжээ, эфирийн цагт ноогдох хувь хэмжээ өөр өөр байдаг.



ЗАРДАЛ

Дээрх хоёр үйлчилгээ эрхлэгчийн бэлтгэх, дамжуулах, техникийн өрөөн дэх программ болон техник хангамжийн хөгжүүлэлтийн зардал өндөр байдаг зэрэг шалтгаануудтай гэж үзэж байна.


ЗАРДЛЫН ХЭЛБЭРҮҮД




Телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд хөтөлбөрт тусгагдсан нэвтрүүлгүүдийн гурван хүртээмжийн үйлчилгээг хийхэд шаардлагатай Хадмал тайлбар, Дохионы хэл, Аудио хөрвүүлгийн ажлуудыг хийхэд техник болон хүн хүчний өндөр зардал гардаг.



Эдгээр бэлтгэгдсэн материалуудыг IPTV үйлчилгээ эрхлэгч хүртэл тусдаа шугамаар дамжуулдаг тул мөн зардал нэмэгддэг. Жишээ нь дохионы хэлний мэдээлэл нь бүтэн телевизийн нэг суваг нэмж дамжуулах хэмжээний зардал гарна.



IPTV үйлчилгээ эрхлэгч нь дээрх гурван профайлыг бүгдийг хэрэгжүүлнэ гэвэл техник хангамж, программ хангамжийн хувьд нэмэлт зардлууд гардаг. Энэ зардлын ихэнх хувийг IPTV үйлчилгээ эрхлэгчийн сонгож авсан нийлүүлэгч компанийн (вендор) программ хангамжийн хөгжүүлэлтийн зардал эзэлдэг байна.



IP TV-ийн хэрэглэгчийн төхөөрөмж хүртэлх хүртээмжийн үйлчилгээний холболтын зураг



IPTV болон Телевизийн үйлчилгээ эрхлэгчийн хүртээмжийн үйлчилгээ явуулах үеийн холболтын зураг



Монгол Улсад нийт өрхийн 98,9% нь телевизийн үйлчилгээг хүлээн авч байгаа мөн өргөн нэвтрүүлгийн хүртээмж хангалттай түвшинд хүрсэн өнөөгийн нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд доор дурдсан олон улсын туршлагаудыг нэвтрүүлэхээс эхлээд үе шаттай ажлуудыг хийж эхлэх нь зүйтэй байна.

01

Олон нийтийн Радио, Телевиз, голлох өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн тухайн өдрийн мэдээний нэвтрүүлгийн тодорхой хувийг тусгай хэрэгцээт иргэдэд зориулдаг

02

Тодорхой цагуудын хооронд сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай мэдээллийн хадмал тайлбарыг телевизийн дэлгэцийн доод хэсэгт байрлуулдаг

03

Хадмал орчуулгатай байх нэвтрүүлгүүд болон VOD захиалгат нэвтрүүлгүүдийг эфирийн цагтаа хувьчилж квот тогтоож дамжуулдаг мэт...





ДҮГНЭЛТ

НЭГ

Дээр дурдсан жишээнүүд нь телевизийн үйлчилгээ эрхлэгч бие дааж өөрийн студид хүртээмжийн үйлчилгээний хэлбэрүүдээс бэлтгэж IPTV үйлчилгээ эрхлэгчид рүү хөтөлбөртөө агуулж дамжуулах хувилбар юм. Энэ журмуудыг бодлогоор боловсруулж хөтөлбөрт нь тусгаж ажиллах, хэвшүүлэх нь эхний алхам юм.

ХОЁР

Монгол Улсын IPTV, Телевизийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын санхүүгийн чадавх дээр дурдсан зөвхөн зөвлөмж боловсруулан ажилладаг ОЛОН УЛСЫН туршлагын дагуу ажиллах хэрэгтэй бөгөөд тусад нь стандарт боловсруулах шаардлагагүй гэж үзэж байна.



ДҮГНЭЛТ

ГУРАВ

Харин хүртээмжийн үйлчилгээг тасралтгүй хөгжүүлж, хэрэгжүүлэх үүднээс зөвлөмжид заасан профайлуудаас хадмал тайлбарыг голчлон хэрэглэдэг Суурь профайлаас (Basic profile) эхлүүлэн энэ ажлыг IPTV үйлчилгээ эрхлэгч, Телевизийн үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран үе шаттай хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу хийж эхлэх нь зүйтэй байна.

IPTV системийн хүртээмжийн профайлын (ITU-T H.702) зөвлөмжийг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлууд

1-р шат


Телевизийн үйлчилгээ эрхлэгч нь бие дааж телевизийн хөтөлбөртөө хүртээмжийн үйлчилгээний хэлбэрийг сонгон өөрийн студид бэлтгэн явуулдаг байх хэлбэрийг журмаар зохицуулж нэвтрүүлэх. Жишээ нь:

- Тухайн өдрийн мэдээний нэвтрүүлгийн тодорхой хувийг тусгай хэрэгцээт иргэдэд зориулдаг;
- Тодорхой цагуудад сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай мэдээллийн хадмал тайлбарыг дэлгэцийн доод хэсэгт байрлуулдаг;
- хадмал орчуулгатай байх нэвтрүүлгүүд болон VOD захиалгат нэвтрүүлгүүдийн эфирийн цагтаа хувьчилж квот тогтоодог гэх мэт

2-р шат

Суурь профайл
(Basic profile)

Хадмал тайлбар
(captions)



3-р шат

Сайжруулсан профайл
(Enhanced profile)

Хадмал тайлбар
(captions)

Дохионы хэл
(sign language)



4-р шат

Үндсэн профайл
(Main profile)

Хадмал тайлбар
(captions)

Дохионы хэл
(sign language)

Аудио хөрвүүлэг
(audio description)





БАЯРЛАЛАА!

www.crc.gov.mn